# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 12 өдөр Дугаар А/22.

Улаанбаатар хот

## Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансt шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 19,872,000.00 (арван есөн сая найман зуун далан хоёр мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Хан-Уул дүүргийн 326 дугаар цэцэрлэгийн балансt шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэг (П.Лхагвасүрэн)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 326 дугаар цэцэрлэг (Б.Нямсүрэн)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

B. Oyunaa

00.000.295.92

1425030048

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 01 . дугаар сарын 12 . -ны өдрийн А/12 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэг

| № | Эд хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Шилжүүлэн авах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоглоомын тавиур | 2024.11.28 | Сайн | ш | 24 | 338,000.00 | 8,112,000.00 | 67600.00 | 8,044,400.00 | Хан-Уул дүүргийн 326 дугаар цэцэрлэг |
| 2 | Багшийн шүүгээ | 2024.12.04 | Сайн | ш | 7 | 600,000.00 | 4,200,000.00 | 35000.00 | 4,165,000.00 | |
| 3 | Багшийн ширээ | 2024.12.04 | Сайн | ш | 5 | 480,000.00 | 2,400,000.00 | 20000.00 | 2,380,000.00 | |
| 4 | Хүүхдийн ширээ | 2024.12.13 | Сайн | ш | 12 | 150,000.00 | 1,800,000.00 | 15000.00 | 1,785,000.00 | |
| 5 | Хүүхдийн сандал | 2024.12.13 | Сайн | ш | 96 | 35,000.00 | 3,360,000.00 | 28000.00 | 3,332,000.00 | |
| **Тавилга, эд хогшлийн дүн** | | | | | | | **19,872,000.00** | **165600.00** | **19,706,400.00** | |
| **Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн** | | | | | | | **19,872,000.00** | **165,600.00** | **19,706,400.00** | |